

**ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
МЭДЭЭЛЭЛ**

2023.08.03

Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагуудын 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны үр дүнд “Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлал”-ын дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангаас мэдээлэв.

**ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
БҮТЦИЙН НЭГЖ, ДЭРГЭДЭХ БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНЭЛГЭЭ**

Гаалийн ерөнхий газрын нэгжүүдийн 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг нийт 248 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 84.46 хувьтай байлаа.

Д/д	Эрэмбэ	Нэр	Үнэлгээ (хувиар)
1	ГАЗАР	Захиргааны удирдлагын газар	87.0
2		Зөрчилтэй тэмцэх, аюулгүй байдлын газар	87.5
3		Санхүү, хөрөнгө оруулалтын газар	86.5
4		Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	85.5
5		Хяналт, бүрдүүлэлтийн газар	89.0
6		Тариф, татварын газар	86.0
7	ХЭЛТЭС	Хүний нөөцийн хэлтэс	88.5
8		Хуулийн хэлтэс	83.0
9		Гадаад хамтын ажиллагааны хэлтэс	82.5
10		Дотоод хяналт, шалгалтын хэлтэс	81.5
11		Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтэс	86
10		Боомтын хөгжлийн хэлтэс	82
13		Эрсдэлийн удирдлагын хэлтэс	87.5
14		Хорио цээрийн хэлтэс	82.5
15		Барааны ангилал, үнэлгээний хэлтэс	82
16		Статистик, дүн шинжилгээний хэлтэс	84
17	ДЭРГЭДЭХ БАЙГУУЛЛАГА	Сургалтын төв	81.5
18		Олон нийттэй харилцах төв	81
19		Инженер техник, аж ахуй үйлчилгээний алба	81
20		Хяналтын нэгдсэн төв	84.5

21		Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газар	85.5
22		Мэдээллийн технологийн газар	86.0
23		Эрэлч нохойн сургалтын төв	85.0
24		Гаалийн төв лаборатори	81.5
Дундаж үнэлгээ			84.46%

ЗӨВЛӨМЖ

1. Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг Улсын Их Хурлын намрын чуулганаар хэлэлцүүлэн, батлуулах;
2. Төсвийн тухай хуулийн 5.1.3-д заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчим, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.10.төрийн үйл ажиллагаа, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байх заалтыг баримталж ажиллах;
3. Гаалийн бүрдүүлэлтийн Цахим нэг төвийн үйл ажиллагааг жигдрүүлэх, гадаад худалдаанд оролцогчдод сурталчлах ажлыг эрчимжүүлэх, учирч буй алдаа дутагдлыг даруй шийдвэрлэж ажиллах;
4. Төрийн албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд нэгээс доошгүй удаа бүрэн хамруулах;
5. Боомтын дэд бүтцийг хөгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, хилийн хяналтын байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр тодорхой үр дүнтэй ажил зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;
6. Гаалийн мэдээллийн автоматжуулсан системийн хөгжүүлэлтийн төслийн хугацаа дуусч буйтай холбоотой гүйцэтгэлийн тайланг нэгтгэн гаргаж хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэх, үр дүнг тооцуулах ажлыг холбогдох нэгжүүд хэрэгжүүлэх;
7. Гаалийн байгууллагын Хэрэглэгчийн үнэлгээний судалгааг сүүлийн хагас жилд зохион байгуулахад анхаарах, хөндлөнгийн байгууллагатай хамтран ажиллах.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР